

# Панграм

Ямарваа өгүүлбэр эсвэл үг нь тухайн хэлний цагаан толгойн бүх үсгийг агуулсан байвал *панграмлеа* гэнэ. Панграмлеа нь ихэвчлэн хэвлэлийн фронт таниулахад эсвэл гаралтын төхөөрөмж шалгахад ашиглагддаг.

Чамд Англи цагаан толгойн том жижиг үсгүүдээс бүтсэн тэмдэгт мөр өгөгдөнө. Энэхүү тэмдэгт мөрийг панграмлеа эсэхийг шалга. Тухайн тэмдэгт мөрөнд Латин цагаан толгойн үсэг том эсвэл жижиг аль ч хэлбэрээр орсон бай уг үсгийг агуулсан гэж үзнэ.

## Оролт

Эхний мөрөнд тэмдэгт мөрийн урт болох  $n$  ( $1 \leq n \leq 100$ ) тоо байна.

Хоёр дахь мөрөнд тэмдэгт мөр өгөгдөнө. Уг тэмдэгт мөр Латин цагаан толгойн том жижиг үсгүүдээс бүтнэ.

## Гаралт

Хэрэв тэмдэгт мөр панграмлеа бол "YES" гэж хэвлэнэ үү. Үгүй бол "NO" гэж хэвлээрэй.

Жишээ тестүүд

**Оролт:**

12

Toosmallword

**Гаралт:**

NO

**Оролт:**

35

TheQuickBrownFoxJumpsOverTheLazyDog

**Гаралт:**

YES